

## ШАРГА СУМД 2017 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2017.04.27

Баянгол

### АЛТАЙН ЭЕШ-2017 –Г СУМДАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэж амжилтыг нь ахиулах, зорьсон сургууль, ангидаа элсэн суралцахад нь дэмжих зорилгоор УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэдийн санаачилсан “ЭЕШ-2017”-г сумдаа зохион байгууллаа. Шалгалтыг сумын Засаг даргын 2017 оны А\10 тоот захирамжаар томилогдсон ажлун хэсэг хөтөлбөр, удирдамжийн дагуу авсан байна .

### АЙМАГТ ЗАЛУУЧУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ОРОЛЦЛОО

Чуулганд аймгийн 18 сум , 2 тосгоны 400 гаруй залуус оролцож санал санаачилга, уриалга гаргаж аймаг орон нутгийнхаа хөгжлийн төлөө хамтдаа зүтгэхээ илэрхийллээ. Чуулганыг аймгийн засаг даргын тамгын газар ,аймгийн залуучуудын холбоо санаачлан , УИХ-н гишүүн Ш.Раднаасэд дэмжин хамтран зохион байгуулсан. Энэ чуулганд сумаас 15 залуу очиж оролцлоо.



### МОД УСЛАХ СУВАГ ШУУДУУ СЭРГЭЭХ АЖЛЫГ ХИЙЛЭЭ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017.03.30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 2017 оныг Иргэдийн оролцоог дэмжих жил

болгон зарласан. Энэ уриан дор албан байгууллага, баг бүр иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн 1-ээс доошгүй бодит ажлыг иргэдийн оролцоотой зохион байгуулахаар болсон.

Энэ ажлын нээлтийг бүтээлч ажлаар эхлүүлж 2017 оны 04 сарын 06, 07-ны өдрүүдэд Баянгол багаас сонгогдсон ИТХ-ын Төлөөлөгчид, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран Урд голын тариалангийн талбайд суваг шуудуу сэргээж мод услах ажлыг хийлээ. Уг арга хэмжээнд төрийн албан хаагчид, Баян гол багаас сонгогдсон ИТХ-н зургаан төлөөлөгч оролцлоо.

Хөдөлмөрийн баатар Лодойхүүгийн үүсгэн байгуулсан 60 жил хоршооны модны усалгааны суваг шуудууг сэргээх 20 орчим жил услагдаагүй моднуудыг усжуулах ажлыг хийсэн.



### **РАШААН БУЛГИЙН ЭХИЙГ ЦЭВЭРЛЭЛЭЭ**

4 сарын 06-ны өдөр Шандын эхийг хамгаалах зорилгоор булгийн эхийн хогийг цэвэрлэх ажлыг хийлээ. Уг нийтийг хамарсан их цэвэрлэгээнд 12 жилийн 8-12-р ангийн сурагчид, төрийн албан хаагчид, Баянгол багаас сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нарын 120 орчим хүн оролцлоо.



### **ОНХС-ИЙН ХӨРӨНГӨ ИРГЭДЭД ҮР ДҮНГЭЭ ӨГЧ БАЙНА**

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан ЗДТГ-ын эзэмшил, ашиглалтанд байсан буудал, халуун ус, үсчин, гуанзны барилгыг сумын Засаг даргын Зөвлөлийн 2017 оны 04 дүгээр хурлаар иргэн Х.Батнасан, Н.Мөнхзаяа, Б.Бадамцэцэг нарт түрээсийн гэрээгээр ашиглуулахаар шийдвэрлүүлээ. Уг барилгад сумын ЗДТГ-аас

цахилгаан халаалтыг өөрчилж 4.5 сая төгрөгөөр нам даралтын халаалт тавьж өгч иргэдийн үйл ажиллагаа явуулах таатай нөхцлийг бүрдүүлж өгсөн байна.

## **ЭМТ-ӨӨС “ОСОЛ ГЭМТЛЭЭС СЭРГИЙЛЬЕ” САРЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Шарга сумын ЭМТ-өөс “осол гэмтлээс сэргийлье” аяныг 1 сарын хугацаатай зохион байгуулаж доорх ажлуудыг зохион байгуулж доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ . Үүнд :

1. Сумын төвийн 4 хорооллын 48 хүнд хүүхдийн түлэгдэл осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж сэдэвт сургалтыг явуулж хүүхдийн түлэгдэл осол гэмтлээс үүдэлтэй сэтгэл гутралаас сэргийлэх талаар мэдээлэл сурталчилгааг 4 багийн 100 гаруй хүнд хийж 120 ширхэг мэдээлэл сурталчилгааны материалыг бэлтгэж тараалаа.

2. 0-5 настай хүүхдүүдтэй айл өрх, эцэг эхчүүдийг, бага насны хүүхдийг түлэгдэлтээс хэрхэн сэргийлэх талаар сургалтыг зохион явууллаа.

3. Мөн 12 жилийн сургуулийн сурагчдад осол гэмтэл түлэгдэлтийн талаар мэдээлэл сурталчилгааны материалыг тараалаа. 4 багийн 180 гаруй айл өрхөд осол гэмтэл хүүхдийн түлэгдэлийн талаар мэдээлэл хийж тараах материал тараалаа.

### **СУМЫН ТАРИАЛАНЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ ХИЙЛЭЭ**

Тариаланчдын үйл ажиллагааг бодлогоор дэмжих, эрчимжүүлэх зорилгоор сумын газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнийг аймгийн Хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд 40 тариаланчийг урилгаар оролцуулж туршлага солилцуулсан. Газар тариалан эрхлэгчдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж тариалангийн талбайг өргөжүүлэх зорилгоор 613 шонг хамгаалалт торны хамт 33 тариаланчид ашиглалтын гэрээгээр хүлээлгэн өглөө.



Мэдээ  
бэлтгэсэн: Д.Ончимэг 99637478